



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот


Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг
өөрчлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн Далхаагийн Лувсанчимэд нь нь Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Б/21 дугаар тушаалаар үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн Төртогтохын Туулыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/05 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны гишүүнээр томилсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хороо /М.Гансэлэм/-нд даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/05 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

